УДК 821.512.36
doi: 10.18101/978-5-9793-0054-2-2017-255-267

М. ПАРЧИН ТУУЛЬЧИЙН ТОВЧ НАМТАР БА УРАН ЧАДВАР

© **Оюун**
преподаватель, Институт молодежной политики Педагогического университета Внутренней Монголии, КНР
КНР, 010020, г. Хух-Хото, ул. Чжаоуда, 81
E-mail: 451110948@qq.com

Монгол Улсын Хяргас сумын туульч баяд ястан М. Парчин нь баруун монголчуудын дунд тууль хайллагаараа алдаршссан XIX зууны сүүл XX зууны эхэн үеийн алдарт туульч билээ. Тэрээр Эргил Түргэл, Бум-Эрдэнэ, Дань Хүрэл гэх мэт олон арван туулсийг хайлдаг байсан бөгөөд тухайн үеийн Зөвлөлт Орос Улсын худалдаачин хожим алдарт монголч эрдэмтэн болсон А.В. Бурдуковтой учирсанаас монгол улсын туульсийг европ дахинд танилцуулах мөн үе үеийн оросын монголч эрдэмтэн болох В. Л. Котвич, Б. Я. Владимирцов нарын монгол судлалын нэгэн шинэ эрин үеийн эхлэлийн тавих учир шалтгаан болсон монгол үндэстний биет бус соелын өвийг тээгч хосгүй нэгэн аман билиг зүйч байсан билээ. Иймд тус туульчийн намтарчлалыг олон арван хүн судалсан боловч түүнийг монгол улсын тууль судлалын нэгэн эрин үеийн эхлүүлсэн тухай үзэлт, болон түүний туульсийн уран дүр дүрслэхүүнийг харьцуулан уран чадварыг тодруулсан өгүүлэл ховор тул энэхүү өгүүлэлээ М. Парчины намтар, тууль хайллагийн уран чадварыг тодруулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: аман зохиол; тууль; оршил; магтаал; уран чадвар; намтар; туурвил зүй; хувилбар; хайллага; дүр.

Монгол тууль судлалын түүхэнд зарим нэг туулийг дагнан судласан ганц сэдэвт бүтээл гарч байсан боловч, тэр үеийн алдартай туульчдыг төлөөлж чадах, онцгой гайхамшигт авьяастай нэгэн туульчийн амьдрал, уран бүтээлийг тал бүрээс нь дагнан судласан зохиол хараахан гараагүй байгаа билээ. Иймд баруун хязгаар нутгийн Баяд ардын нэрд гарсан туульч, Монголын ард түмний бахархал болж байсан Маньтханы Парчингийн (1855–1926) амьдрал байдал, ажил үйлс, олныг бишрүүлсэн уран чадварыг энэхүү өгүүлэлдээ гаргахыг зорилоо. Хэзээнээсээ малч удмын монгогын ард түмэн, ур хүүхэд, өсвөр хойч үеийнхнээ бага балчир байхаас нь ардын аман зохиолын яруу сайхан амт шимтийг мэдрүүлж, үлгэр, ерөөл магтаал хэлж өгч, оньсого таавар таалгаж, эх сайхан нутаг, эгэл олон түмнээ эрэлхэгээр хамгаалан тэмцэгч эзэн баатар эрийн тухай тууль хайлж, зан үйл бэлгэ дэмбэрлийн үгс хэлэлцэж, ухаан санааг нь хөгжөөн, эрэлхэг баатарлагийн үлгэр жишээгээр нь эх оронч үзэл санаагаар хүмүүжүүлж ирсэн юм. Ийм цэцэн туульчдын нэг нь алдарт туульч М. Парчин байв.

Монгол орны баруун хязгаар нутгийн нэрд гарсан алдарт туульч М. Парчин билгийн тооллын XIV жарны хөхөгчин туулай жилийн намрын дунд сарын 15-нд буюу аргын тооллын 1855 оны 9 дүгээр сарын 13 нд одоогийн Увс аймгийн Хяргас сумын нутэгт ядуу тайж Чорос овогт Маньтханы хоердугаар хүү болон төржээ. М. Парчин лам болохоор Дэжээлэнгийн хүрээнд сууж байгаад хийдээс оргож хөдөө гэртээ харьж, гэзэг тавьж төрийн хар хүн болж, аав ээждээ гэр орных нь ажилд туслалцаж малаа маллаж, тариагаа тарьж, ан

гөрөө хийж арьс нэхий элдэж, малынхаа ашиг шим, сүү саалийг боловсруулан ашиглаж завсар чөлөөнд нь туулиа хайлж амьдрах болов. Амьдрал нь ядуу тул аав ээж гэр орныхондоо туслаж маш их ажил хийх шаардлагатай байлаа. М. Парчингийнх цөөн тооны бог малтай, унааны морь, саалийн үнээтэй, түүнийгээ маллаж Булган уулаа эргэн тойрон, бууцаа сэлгэн нүүж жилийн дөрвөн улирлыг өнгөрөөдөг байв.

Доктор профессор Д. Цэнд «М. Парчин туульч аж амьдралын хувьд ядуу жирийн хүний байдлаар хөдөлмөрлөж амь зууж байсан ба хөрөнгө хогшил нь 20-иод ямаа, 2 тугалтай үнээ, унааны морьтой, ... хошууныхаа айлуудын хуц авч хариулан үс ноосыг нь ашигладаг байсан байна» гэж алдарт туульч М. Парчинтай холбогдох мэдээ гэдэг өгүүлэлдээ бичжээ [Аман зохиол судлал, XX боть, 1997, 164-165 тал]. М. Парчин туульчийнх малынхаа сүү сааль, ашиг шимээр амьдрахын зэрэгцээ амьдралын нэг гол зүйл нь тариа тарьж байсан байна. Тэднийх Хангилцагийн голын хөвөөнд тариа тарьдаг хувийн жижиг талбайтай (ангистай) байжээ. Тэндээ жил бүр тариа тарьж усалж тордож тарианыхаа дэргэдэх шавар амбаартаа хавар гарч намар хүртэл ажиллаж, ургацаа хурааж тарианы гурил, хөц будаа хийж идэж, ам бүлээ тэжээн, амьдралаа тэтгэж багаасаа эцгийгээ дагаж тариа тарих хураах ажилд нь оролцож тусалсаар яваад сайн тариачин болсон байна. Мал цөөтэй байсан тул самар жимс, мөөг түүж тарианы гурилаар хүнсэндээ нэмэр хийж, байгалийн баялаг ашиглан амьдардаг байсан ажээ. Парчин туульч тарианы ажилд дадлагажсан хүн байсан ба тэднийд тариа тарих хураах, гурил хийх бүх хэрэгсэл, төмөр хошуутай модон анжис, төмөр хүрз, газар хагалахад зүтгүүлдэг үхэр тэмээний тохош, уур нүдүүр, чулуун тээрэм зэрэг багаж байсан ба түүнийгээ залуу хүмүүст үзүүлж зааж сургаж «тариа тарьж сур, залхуурч болохгүй. Тариа нь хангай дэлхийн хайрласан, ширгэшгүй тэжээл бөгөөд гэдэс цатгалан явах үндэс юм» гэж хүмүүсд ярих дуртай байсан юм гэж эрдэмтэн Д. Цэнд бичсэн байна [Аман зохиол судлал, XX боть, 1997, 165 тал]. М. Парчин тариагаа тарьж усалж тордож, тариан дээрээ ажиллаж, Хангилцагийн голд явж байгаад л тэнд ажиллаж амьдарч байсан Оросын иргэн А.В. Бурдуковтой уулзан танилцаж, М. Парчины үйл амьдралын талаар А.В. Бурдуков судалж дэлхийн монголыг судлаач эрдэмтдэд хүргэх сайхан боломж олдсон нь өгөөж баян газар тариалангийн ажил нь л түүнийг алдаршуулахад тусалсан бололтой. Мөн М. Парчин туульч бага зэрэг ан гөрөө хийж амьдралдаа нэмэр болгодог анчин хүн байв. Хэдэн хавхтай байсан. Түүнийгээ намар болж тарвага таргалахаар тарваганы нүх «сахиулж» хааяа нэг бурхи бүдрээгээд идчихнэ. Өвөл болж цас орж хүйтрэхээр мөнөөх хэдэн хавхаа «нүд анисан» буюу «боохой зооглосон» малын сэг зэм мал нядалсан газар бараадуулж ганц нэг үнэг хярс бариàд малгай хийгээд өмсчихнө. Хананыхаа толгойноос утаа тортог болтол нь өлгөсөн цахиур буугаараа эгзэг нь таарвал чоно, тарвага, бор гөрөөс зэргийг хааяа унагачихдаг, яггүй мэргэн бууддаг бууч хүн байжээ. Гэхдээ ангийн хойноос хө°цөлдөөд явдаггүй, тийм зав ч үгүй байлаа. М. Парчин туульч зохиосон уран бүтээлдээ төрж өссөн нутаг ус уул хангай, амьдралын эх сурвалж болж байсан мал сүргээ магтан дуулах их дуртай байсан юм. Тэр өөрийнхөө төрж өссөн, эргэн тойрон нутаглаж малаа маллаж амьдарч байсан Булган хангай уулынхаа маггаалд:

Ар талын ой шугуйд нь
Амтат жимсээр элбэг

Өвөр талын ам хөндийд нь
Ундармал усаар элбэг
Булган хангай нутаг минь
Ар талд нь буусан айлууд
Айраг таргаар элбэг байдаг
Өвөр талд нь буусан айлууд
Өрөм зөөхийгээр бялхан байдаг
Өнтэй тарган өгөөмөр баян
Булган хангай нутаг минь...

гэх зэргээр магтан шүлэглэсэн байдаг. Туульч М. Парчин баян чинээлэг элбэг дэлбэг амьдарч байгаагүй ч ямарч шуналгүй эд хогшил хөрөнгө мөнгө цуглуулдаггүй, хүмүүс тууль хайлуулаад өгсөн бэлэг сэлтийг тухайн үед нь зарцуулж хэрэглэчихээд л явж байдаг сэтгэл хангалуун, хүнийг их бага дээр доор гэж ялгадагүй бүх хүнийг хүндэлдэг зан харьцаа сайтай эелдэг сайхан ааштай ес есорхог, хүүхэд залуу хүмүүст ахын есоор амьдралын сургамж хэлж явдаг намбатай сайхан нэр хүндтэй хүн байсан тул, жирийн олон түмнээс эхлээд ихэс дээдэс хэнч байсан түүнийг их хүндэлдэг байжээ. Хурим, найр наадам, баяр еслол, овоо тахилга зэрэг хүмүүс олноороо цугласан газарт эхэнд нь суучихсан тууль хайлж ерөөл магтаал хэлж олон түмний анхаарлыг татаж хөгжөөн баясгаж байсан тухай тэр үеийн ахмадууд дурсан ярьдаг юм. М. Парчин шатар нэлээд тоглодог, хорол тоглодог, гаанс тамхинаас салдаггүй, монгол төвд ном нилээд уншдаг, хар авдар дүүрэн номтой, түүнд нь хөлгөн судраас авахуулаад түүхийн холбогдолтой номнууд нилээд байдаг байжээ. М. Парчин гадаад дотоодын эрдэмтэд судлаачид болон олон түмний анхаарлыг татсан гайхамшигт туульч болж, уран чадвар нь жилээс жилд хөгжин дээшлэх шимтэй хөрс, нөлөөлөх хүчин зүйлүүд тэр үеийн монголчуудын дунд элбэг байсан учир зуун зууныг дамжин алдар нэр нь цуурайтсан нэрт туульч болж чадсан байна. Тэр үед анги танхимын зохион байгуулалттай сургууль соелын газар монголд байгаагүй тул М. Парчин авга ах Санжаа тайж, нэг нутгийн Жалцан тайж, Өлзий мээрэн зэрэг гэрийн багшаар бичиг үсэг заалгаж, тэр үеийн баядын том хүрээ хийд байсан Дэжээлэнгийн хүрээнд шавилан сууж, монгол тод бичиг мэддэг болж, анхан шатны боловсрол олж авсан байна.

М. Парчинг алдарт туульч болоход нөлөөлсөн хүчин зүйл гэвэл юуны өмнө өөрийнх нь гайхамшигт гоц авъяас чадвар, туульч болох хүсэл сонирхол, уйгагүй зүтгэл, идэвх чармайлт, ажилсаг чанар нь нөлөөлсөн юм. М. Парчин хүүхэд байхаасаа маш их сэргэлэн цовоо, сонссон дуулсанаа дор нь тогтоох чадвартай, түүнийгээ мартдаггүй, ой тогтоолт сайтай, ардын аман зохиол, үлгэр тууль, ерөөл магтаалыг шимтэн сонсдог, цээжлэн ярих дуртай байв. М. Парчин сурч мэдэхийн төлөө байнга чармайж, цаг заваа ашиглан, мэрийж явдаг байсан тул 4-5 мянган мөр шүлэгтэй том том туулиудыг дор нь сурч, аялгуулан хайлж өөрийн авьяас билиг уран чадвараараа улам баяжуулж байжээ. М. Парчинг уран чадварлаг туульч болоход нөлөөлсөн өөр нэг хүчин зүйл нь тэр үеийн баруун монголчууд, одоогийн Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн Дөрвөд, Баяд, Урианхай, Захчин, Торгууд зэрэг олон ястан ард түмний дунд болон, хөрш зэргэлдээ, үндэс угсаа нэгт, Тагна Тувагийн Урианхай, Элистагийн Халимаг, Буриад зэрэг нутгуудад туульч олон, тууль элбэг байсан нь хүчтэй нөлөөлсөн ажээ

М. Парчин алс холын хязгаар нутагт амьдардаг нүүдэлч малчдын дундаас алдарт туульч болж, нэр алдар нь түгэн дэлгэрэхэд нөлөөлсөн гуравдахь хүчин зүйл нь тууль хайлж эхэлсэн бага залуу наснаас нь туульд дуртай хол ойрын ард иргэд хийгээд ноед ихэс дээдэс хүртэл гэртээ урьж тууль хайлуулж алдаршуулж байв.

М. Парчинг арван баядын хошуугаар барахгүй, Дөрвөд далай хан аймгийн Улаангомын Чин ван, Хан Хөхий уулын хошууны засаг ноен С. Лувсандондов гүн зэрэг аймаг хошуудын засаг ноед, нэр алдартай хүмүүс урьж тууль хайлуулж, ерөөл магтаал хэлүүлж байв. Үүнд XIX зууны сүүлч XX зууны эхэн үеийн Монгол Улсын төрийн зүтгэлтэн яруу найрагч соен гэгээрүүлэгч, тэр үеийн засагт хан аймгийн ачит вангийн хошуу буюу Хан Хөхий уулын хошуу, одоогийн Увс аймгийн Өндөрхангай сум, үе залгамжилсан засаг ноен Сэдбазарын Лувсандондов гүн (1854-1909) Баядын их туульч М. Парчинг Хан Хөхий нутагтаа урьж тууль хайлуулж ерөөл магтаал хэлүүлж 1880 онд өөрөө зохиосон 400-аад мөр шүлэг бүхий «Эрдэнэт богд Хан Хөхийн магтаал»-ыг аялгуулан хэлүүлж байжээ. М. Парчин туульч хамгийн үнэн зөв үнэлэлтийг сонсогч олон түмнээсээ авдаг байв. М. Парчингийн тууль хайлахыг сонссон, ноед дээдэс, лам хувраг, харц ардууд, сонсогч, судлаачид хэн ч байсан, магтан сайшааж, баярлан талархаж байсан байна. Энэ нь түүний бусдаас ялгарах уран чадварын онцлогийг олон түмнээс үнэлсэн өндөр үнэлэлт байлаа.

Доктор, профессор С. Лувсанвандан «Туульч шинжээч хоер» хэмээх өгүүлэлдээ «Туулийг хайлах урлаг нь, туулийн шүлгийг цээжлэн унших нэр биш, зохиолын үйл явдлаар амьдарч, зохиолын дүрд хувилан, туулийн ур, ухаан хоерыг амилуулах эрдэм, шүлэглэн өгүүлэх, дуулан хөгжимдөх уран чадвар билээ. Тиймээс ч тууль хайлах урлагийг, нэг жүжигчинтэй театртай зүйрлэдэг нь тохиолдлын адилтгал бишээ. Яруу шүлэг, уянгалаг аялгуу, хөгжмийн эгшиг нь туульчийн дүрд нэгэн цогцос болж, үзэгчдийн нүднээ амилж, сонсголд урган, сэтгэл оюунд нь нэвтэрдэг байна. Тийм билиг авьяас төгс, ухаан эрдэм төгөлдөр уран бүтээлчийн нэг бол М. Парчин туульч байлаа» гэж бичжээ [Аман зохиол судлал, XX боть, 1997, 150-р тал].

Туулийг амьдруулагч М. Парчин мэтийн авьяаслаг аман зохиолчид, нэрт туульчид нь туулиа хайлахдаа жүжигчин, товшуураа барихдаа хөгжимчин, толгой холбохдоо найрагч байлаа. М. Парчин туульчийн тууль хайлах уран чадвар үнэхээр гайхамшигтай байсан тухай нутгийн зарим настайчууд дурсан ярихдаа: «Туульч тайжийг туулиа хайлж байхыг саахалтын газраас сонссон ороо буур гэрийнх нь үүдэнд ирээд хүрхэрч байж билээ» гэж ярьдаг байсан гэнэ. «Үүнээс үзвэл ухаантай» мэргэн хүнийг байтугай, ууртай догшин адгуусыг ч уяртал тууль хайлдаг хүн байж дээ гэж бодогдоно» гэж доктор Ц. Өнөрбаян бичсэн байна. Х. Сампилдэндэв «Алдарт туульч М. Парчин ба түүний уран бүтээлийн судалгаа» хэмээх өгүүлэлдээ «Алдарт туульч М. Парчин бол баруун Монголын ард түмний олон туулийг залгамжлан хөгжүүлж туульчийн уран чадварыг төгс эзэмшин хойч үедээ уламжлуулан, орчлон дахинаа алдаршуулж, манай ард түмний дунд төдийгүй, дэлхийн монголч эрдэмтдийн дунд нэрд гарсан туульч билээ. Увс нутгийн, Баяд ардын дунд ийм нэгэн алдарт туульч төрж, монгол туулийн хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулсан юм. Иймд М. Парчин хуучин утгаар зөвхөн туульч байсангүй, өнөөгийн ойлголтоор сайн зохиолч, сод авъяастан нийгмийн зүтгэлтэн, монгол туульсыг бүтээлчээр хөгжүүлэн баяжуулах, ур чадвартай туульчдын залгамж үе

төрөн гарахад бүтээлээрээ үлэмжхэн нөлөө үзүүлсэн нэрт туульч юм» гэж бичжээ. М. Парчин бол урьдах олон үеийнхээ туульчдын оюуны арвин баялаг ололт бүтээлийг залгамжлан авч, хөгжүүлэн баяжуулж олон шилдэг туульчдад мэргэжлийн өндөр түвшинд дамжуулан өгсөн туульч юм. М. Парчин туульчийн амьдрал, уран бүтээлийг судлах, сурталчилан таниулах, олон түмэнд хүргэх талаар гадаад дотоодын судлаачид эрдэмтэдийн хийсэн судалгааны ажлыг хоер үе болгон авч үзэж болно.

Нэгдүгээр үе нь 1909-1940 он хүртэл, оросын эрдэмтэд А. В. Бурдуков, В. Л. Котвич, Б. Я. Владимирцов нар М. Парчин туульчийн амьдрал үйлсийг судлаж байсан үе юм. XX зууны эхэн үед оросын дээрхи эрдэмтэд монголын баруун хязгаарт ирж, Хангилцагийн голд ажиллаж амьдарч байхдаа М. Парчинтай танилцаж, түүний хайлдаг туулиуд болон баруун монголын олон ястны аман зохиолыг сурвалжлан олж, Санкт-Петербургийн их сургуулийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн судлаач эрдэмтэдийн гарт хүргэж байсан үе юм. Монгол тууль судлал, М. Парчин судлалын эхийг тавихад онцгой үүрэг гүйцэтгэсэн хүн бол оросын монголч эрдэмтэн А. В. Бурдуков (1883–1943) юм. Тэр Монголд нийтдээ 30 гаруй жил ажилласан, Монголын газар нутаг ард түмнийг чин сааначаасаа хүндэтгэдэг шударга үнэнч, хүнлэг сайхан сэтгэлтэй орос хүн байсан ажээ.

Монгол судлалд өөрийн амьдрал, ухамрсарт үйл ажиллагаагаа зориулсан оросын өөр нэг нэрт эрдэмтэн Борис Яковлевич Владимирцов (1884–1931) Монгол ардын аман зохиол, түүх, угсаатны зүй, хэл шинжлэлийн талаар олон жил судалгааны ажил хийж, монгол судлалын талаар тухайн үеийн тулгамдсан асуудлуудад өөрийн зохиол бүтээлийг зориулж, олон чухал бүтээл туурвисан байна. Ялангуяа тэр үеийн баруун монголын ард түмний дунд ихэд түгэн дэлгэрсэн баатарлаг туульсыг судлах, алдарт туульч М. Парчины хайлж байсан томоохон туулиуд, ерөөл магтаалуудыг бичиж тэмдэглэж авах, туульч М. Парчин хийгээд өрнөд монголын баатарлаг туульсыг дэлхий дахинд алдаршуулахад анхны алхамуудыг хийж их үүрэг гүйцэтгэсэн эрдэмтэн юм.

Б. Я. Владимирцов Монголд удаан хугацаагаар ажиллаж амьдарсан, баруун монголын хэл аялгуу зан заншил, аж амьдралыг сайн мэдэх А. В. Бурдуковтой ойр дотно нөхөрлөж түүгээр зуучлуулан монгол орон, монголын ард түмний соел иргэншил, аман зохиол, тууль судлалын холбогдолтой олон арван материал цуглуулан авч судалгааны хүрээнд оруулсан юм. А. В. Бурдуковын идэвхитэй туслалцаа, зүтгэл чармайлтын ачаар Б. Я. Владимирцовын цуглуулсан ардын аман зохиолын баялаг материал М. Парчины хайлсан туулиуд одоо Санкт-Петербургт хадгалагдаж байгаа гэнэ. Б. Я. Владимирцов эдгээр судалгааны материалдаа тулгуурлан, монголын баатарлаг туульсын тухай, дэлгэрэнг¿й оршил бичиж, «Бум-Эрдэнэ», «Дань Хүрэл», «Хийгийн хүйтэн хөх төмөр зэв», «Эгэл Мэргэн», «Эргэл Түргэл», «Шар бодон» зэрэг зургаан том туулийг нь Орос хэлэнд орчуулан, «Хийгийн хүйтэн хөх төмөр зэв» «Эргэл Түргэл» гэдэг хоер туулийг нь галиг үсгээр тэмдэглэн авч нийтлүүлжээ. Б. Я. Владимирцов ийнхүү М. Парчины хайлдаг туулиуд дээр ажиллан, заримыг монгол эхээр нь, заримыг орос орчуулгаар бас заримыг нь галиг үсгээр хэвлүүлэхийн зэрэгцээ задлан шинжилж, Ойрад, Халимаг, Буриад туульсын холбоо уялдаа, агуулга зохиомж, тууль хайлах ес горим, зурэг асуудлыг хөндөн тодорхой саналууд дэвшүүлсэн юм.

Алдарт туульч М. Парчины судалгааны хоердугаар үе нь монгол оронд боловсрол мэдлэгтэй үндэсний эрдэмтэн сэхээтэн өсч бойжиж судалгаа шин-

жилгээний ажлыг нэлээд өргөн хүрээнд хийх болсон 1960-аад оноос хойших үе хамаарна. XX зууны эхнээс 1940 он хүртэл судалгааны ажлын эхлэлийг Оросын эрдэмтэд хийж байсныг дээр өгүүлсэн билээ. 1940–1960-аад оны үед манай оронд судалгааны ажил хийх боловсрол чадвартай, үндэсний сэхээтэн маш цөөн, судалгаа шинжилгээний ажил эхлэлтийн төдий байсан юм. Энэ нь хэд хэдэн шалтгаантай билээ. Олон жил харийн түрэмгийлэгчдийн эрхшээлд, сургууль соелын газаргүй байсан монгол оронд 1930-аад оны үеэс үндэсний сургууль соелын газрууд байгуулагдаж байсан боловч, мэдлэг боловсролтой сэхээтэн олон байгаагүйн зэрэгцээ ард түмний маань тухайн үеийн оюуны чадавхтай хэсэг болох олон мянган лам нар, сор болсон сэхээтнүүд нь 1937–1939 оны их хэлмэгдүүлэлтэнд өртсөний дараах үе байсан юм. Мөн энэ үед дэлхийн 2-р дайны хүнд үе тохиож, түүний хор нөлөөг арилгах олон чухал алхам хийгдэж байсан үе юм. 1960-аад оноос боловсрол мэдлэгтэй боловсон хүчний арми өсөж, эрдмийн зэрэг цолтой хүмүүс олширч эрдэм шинжилгээ судалгааны ажлын эхлэл нийгмийн амьдралын бүх хүрээнд тавигдаж байлаа. Энэ үеэс л ардын аман зохиол, түүний дотор алдарт туульч М. Парчины амьдрал үйлсийг судлах ажлын хоердугаар үе эхэлж, XX зууны эхнээс эхэлж 1940 он хүртэл Оросын эрдэмтэдийн хийж байсан ажлыг цааш нь гүнзгийрүүлэн судлах бололцоотой болж ирсэн юм. 1960-аад оны эхнээс л «Цог», «Шинжлэх ухаан амьдрал» сэтгүүл, «Утга зохиол урлаг» сонин, төвийн зарим хэвлэлүүдэд монгол тууль судлал М. Парчин туульчийн талаар судалгааны өгүүлэлүүд нийтлэгдэх болсон юм.

1965 онд анх удаа Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын Хүрээлэнгээс М. Парчины мэндэлсний 110 жилийн ойг тэмдэглэж, эрдэм шинжилгээний бага хурал хийлгэж, 1966 онд «Монгол ардын баатарлаг туульсын учир» ном хэвлүүлсэн юм. Туульч М. Парчины мэндэлсний 110 жилийн ойд бэлтгэх ажлын явцад М. Парчины холбогдолтой судалгааны өгүүллүүд хэвлэгдэж байлаа. Үүнд Т. Галсан «Баруун Монголын М. Парчин туульч» («Цог» сэтгүүл. 1962. № 2) Д. Дашдорж «Түмэн үед дуурсах эгшиг» өгүүлэл («Шинжлэх Ухаан амьдрал» сэтгүүл, УБ, 1965, 05) У. Загдсүрэн «Туульч М. Парчины амьдрал уран бүтээлийн тухай» зэрэг монгол сэхээтний бичсэн судалгааны анхны өгүүллүүд хэвлэгдэн гарав.

Туульч М. Парчины мэндэлсний 120 жилийн ойг 1975 онд, 130 жилийн ойг 1985 онд, 140 жилийн ойг 1995 онд, 150 жилийн ойг 2005 онд өргөн тэмдэглэсэн бөгөөд засгийн газрын 1995 оны 6 сарын 7-ны 91-р тогтоолоор Увс аймгийн Хяргас сумын 10 жилийн дунд сургуулийг М. Парчины нэрэмжит болгож, нэр алдрыг нь мөнхжүүлсэн юм.

1909 онд Польшийн монголч эрдэмтэн профессер В. Котвичийн хүсэлтээр орос эрдэмтэн А. Бурдуков, Баядын туульч М. Парчингаас «Бурхан хаан аавтай бурам хатан ээжтэй Эрийн сайн Бум Эрдэнэ» гэдэг есөн бүлэг туулийг баяд бичээч М. Мажараар бичүүлсэн хувилбар.Уг эхийг худма монгол эхээс 1983 онд Х. Лувсанбалдан крилл монгол бичигт буулган хэвлүүлсэн хувилбар.

1925 онд Ц. Д. Номинханов туульчин У. Батаагаас бичсэн хувилбар, 1947 оны Ц. Цэдэнжавын хувилбар, 1967 онд Ж. Цолоо туульч У. Батаас соронзон туузанд шингээж бичсэн хувилбар, мөн 1972 онд «Аман зохиол судлал» цувралын долдугаар ботийн 10 дахь дэвтэрт хэвлэгдсэн туульч М. Парчингийн хувилбар, 1985 онд Б. Катуугийн М. Парчин, У. Бат нарын хувилбараас уран дүрслэлтэй хэсгийг нь сонгон авч найруулан эмхтгэсэн хувилбар, мөн Б. Ка-

туугийн «Баяд ардын тууль» УБ, 2001 он хэмээх номонд тавигдсан бас нэгэн өөр хувилбар гэхчлэн нийт долоон хувилбар байна. Бум Эрдэнэ туулийг хайлахын өмнө товшлуур хөгжмийн аянд туулийн оршил магтаалыг өгүүлэн хэлдэг байснаас гадна туулиа жаргаахын эцэст төгсгөлийн ерөөл хэлж дуусгадаг байжээ.

Тууль хайлахын өмнө хэлдэг оршил хэсгийн магтаал нь дээрх долоон хувилбаруудад зарим нэгэнд нь байхгүй. Ж. Цолоо оршил хэсгийн магтаалын олон хувилбарыг «Бурхан хааны хөвүүн балчир Бум Эрдэнэ», УБ 2009 гэх бүтээлдээ эмхэтгэсэн нь одоогоор Бум Эрдэнэ туулийн судалгааны хамгийн сүүлийнх юм. Дээрх хувилбаруудаас 1967 оны Ж. Цолоогийн хувилбар нь хамгийн олон мөр шүлэгтэй буюу нийт 430 орчим мөр шүлэгтэй оршил хэсгийн магтаал болно. Хамгийн бага хэмжээтэй нь 1983 оны Х. Лувсанбалдангийн хувилбар 170 орчим мөр шүлэгтэй оршил хэсгийн магтаал байна. Дээрх долоон хувилбарыг ажиглавал ижил ба ялгаатай дүр дүрслэгдэхүүн харагдах бөгөөд туулийн агуулгыг хэд хэдэн бүлэгт ангилж олон өгүүлэмжид оруулан тодорхойлон харьцуулан судалсан зүйл одоогоор байхгүй байна.

Иймийн тулд 1925 оны Ц. Д. Номинхановын хувилбарыг 1983 оны Х. Лувсанбалдан кирилл монгол бичигт буулгасан «Бум Эрдэнэ» туулийн зөвхөн оршил хэсгийн магтаалтай харьцуулан дүр дүрслэл хийгээд логик дараалаар нь ялган олон өгүүлэмжийн ангилалд оруулбал Ц. Д. Номинхановын хувилбарыг цаг үеийн магтаал, алтай хангай нутгийн магтаал, говь нутгийн магтаал, ан амьтны магтаал, гол мөрөн, нуур, далай тэнгисийн магтаал, рашаан булаг усны магтаал, мод ургамал, жигүүртэн шувуун магтаал, адуун сүргийн магтаал,тэмээн сүргийн магтаал, үхэр сүргийн магтаал, хонин сүргийн магтаал, ар гүн, албат иргэдийн магтаал хэмээн 12 өгүүлэмжийг ангилан судлахыг оролдсон болно. Энд товчилохын үүднээс 1983 оны Х. Лувсанбалдангийн хувилбарыг /А/ хувилбар, 1925 оны Ц. Д. Номинхановын хувилбарыг /Б/ хувилбар хэмээн нэрийдэв. /А/ хувилбарыг цаг үеийн магтаал, алтай хангай нутгийн магтаал, говь нутгийн магтаал, ан амьтны магтаал, гол мөрөн, нуур, далай тэнгисийн магтаал, рашаан булаг усны магтаал, адуун сүргийн магтаал,тэмээн сүргийн магтаал, үхэр сүргийн магтаал, хонин сүргийн магтаал, сүм дуганы магтаал хэмээн арван нэгэн өгүүлэмжид ангилан хоер хувилбарын өгүүлэмж бүрийн ойр төстөй хийгээд нийтлэг буюу ялгаатай дүрслэгдэхүүн юу байна гэдгийг үзэхэд ерөнхий агуулгын хувьд таарч байгаа зүйлс нэлээд байгаа боловч дүр дүрслэл, мөрийн тоо, мотивийн дараалал өөр өөр болох нь харагдах юм.

Дээрх хоер хувилбарын өгүүлэмж (мотив) бүрийн доор зарим нэг үгийн тайлбар хадан ялгаатай буюу нийтлэг талыг тодорхой хэдэн өгүүлэмжийг сонгон авч тус бүрийн магтаалын шүлэгтэй нь харьцуулан үзвэл. Нэгдүгээрт /А/ хувилбарын «Цаг үеийн магтаал»

Эрт урд өнгөрсөн төв сайхан
Түмэн галавын сүүл
Эдүгээ ирээгүй байх
Төвшин сайхан мянган галавын эхэн завсарт
Энх амар бум олон настай
Төгс дэлгэр түмэн арвин буянтай
5. Төвшин их жаргалтай баян өргөн баатар дайч
Бат төв төвшин нэгэн сайн цагт гэлээ лөө

Нарны хөл тогтон туниараад
Найман түмэн насыг эхэлж
Найман түмэн дөрвөн мянган
10. Номын цогцыг номнож байхын нэгэн сайн цагт

Тогтсон төр шажин гэлээ лөө хэмээн цаг үеийг «төв сайхан түмэн галав, төвшин сайхан мянган галавын эхэн завсарт» гэсэн нь хоер галавын хамгийн жижиг буюу завсрын галавын үед «Баян өргөн, баатар дайч, бат төв төвшин нэгэн сайн цагт» гэсэн нь байгаль дэлхийн баян тансаг эрдэнэс, хэмжээлшгүй уудам газар нутагт баатарлаг иргэн хүмүүс дайн дажингүй, энх тунх амьдран сууж байх нэгэн тайван жаргалтай цаг үеийг дүрсэлсэн байна.

Энэ үед «номын цогцыг номнож байхын нэгэн сайн цагт тогтсон төр шажин гэлээ лөө» гэж төр, шашин жинхэнэ утгаараа бүрэлдэн бий болсон хэмээн дүрсэлсэн бол

Төв сайхан түмэн галавын
Түвшин сайхан мянган галавын
/Б/ хувилбарын «Цаг үеийн магтаалд»
Эрт урд өнгөрсөн
Эхэн завсар дунд
Гарах шар нарнаа
5 Гэрэл мандан туяараад
Газар дэлхий хоер
Нэгэн дэлгэрээд байдаг
Орох шар нарны гэрэл тогтон туяараад
Орон замбуй тив нэгэн дэлгэрээд байдаг
10 Нарны гэрэл саяхан мандан туяараад
Найман түмэн насыг насалж
Баян өргөн
Бат дайчин
Бат төв түвшин

Төр шашин хэмээх өгүүлэмж нь дээрх /А/ хувилбараас ялгаатай юм. Жишээлбэл: /Б/ хувилбарт «газар дэлхий хоер нэгэн дэлгэрээд орох шар нарны гэрэл тогтон туяараад орон замбу тив нэгэн дэлгэрээд» гэсэн нь /А/ хувилбарт байхгүй бөгөөд энд ертөнц дэлхий, саран нарны үүсэл нэгэн зүйл сурталыг хүмүүний замба тив цоо шинээр бүрэлдэн үүсч буйгаар дүрсэлсэн байна.

/А/ хувилбарын хоердугаар өгүүлэмж болох «Алтай нутгийн магтаалд»
Хий нэгэнтэй түшилцэн ургасан
Ташир тавин хаантай нутаг дүнхийгээд
Оно даваагүй авалцаж ургасан
Хөвч нэгэнтэй давхар далан Алтай уул ярайгаад
Цасан зоотой тавин шил цайлзаад
15. /2а/ Мөсөн мөргөтэй наян сүвт / уулын ам/

Гялавхийгээд байдаг гэж /12-16/-р мөрөнд шүлгэлсэн бол /Б/ хувилбарын «Алтай нутгийн магтаал»
Ой хөвч үгүй ташуудаад тогтсон
Ташир тавин таван
Хангай дүнхийгээд байдаг.
Он даваа үгүй авалцаад тогтсон
Арван найман сайхан алтай нутаг

Хөвч нь нэгтэй
Хөхүй нутаг
Цасан зоотой тавин шил цайлзаад байдаг
25 Мөс нь мөргөтөө
Наян гөвдөг шил гялалзаад байдаг
Битүү далан цахран цайлзаад байдаг
Бөглүү тавин хар бут ургаад байдаг.

Зургаан зүйлийн өргөн сайхан алтан нутаг гэлээ хэмээн /18-28/ мөрөнд шүлэглсэн ба /А/ хувилбарт «Ташир тавин хаантай нутаг дүнхийгээд» гэж тэр нутаг ус нь эзэн хаант төрийн тогтолцоотой гэх санаа агуулсан бол /Б/ Ташир тавин таван хангай дүнхийгээд байдаг гэх ялгаа байна.

/Б/ хувилбарт уулын ташуу /зэрэгцээ/ 55 н хангай хэмээн бичсэн нь дүрслэл логикийн хувьд Б хувилбар нь илүү зохимжтой санагдана. Мөн /А/ хувилбарт «Хөвч нэгэнтэй давхар далан Алтай уул ярайгаад, гэсэн бол /Б/ «Арван найман сайхан алтай нутаг» гэж далан алтай, арван найман Алтай хэмээн хэтрүүлэл ихэсгэл тоон билгэдэлийн зөрүү харагдаж байна.

/А/ хувилбарын алтай нутгийн магтаал нь /12-16/-р мөрөнд. /Б/ хувилбарын магтаал нь /18-28/ мөрөнд дүрсэлсэнийг харвал өгүүлэмжийн байр суурийг өөр өөр, бичсэн нь харагдаж байна. Өөр өөр шинэ дүрслэл сүүлийн /Б/ хувилбарын 26, 27, 28 дахь мөр шүлэг нь дээрх А хувилбарт огт байхгүй.Энэ мөр шүлэг нь сүүлд, шинээр Парчин туульчийн уран сэтгэмжээр баяжигдан нэмэгдсэн бололтой.

Мөн Говь нутгийн магтаал нь хоер хувилбарт харилцан адилгүй байна. Энэ нь өгүүлэмжийн шугамын байрлал мөрийн тоо зэрэг нь өөр болох нь харагдах юм. /А/хувилбарын «Говь нутгийн магтаал»

Хөлөг морин хөшин цолрон хүрч болшгүй
Гучин гурван их говь жирийгээд
Эр хүн эндээн төөрөөд эргэж болшгүй
Далан найман далан улаан элсэн сонжирч
дүнхийгээд байдаг
10. Сар сараар туулан өнгөрч болшгүй
Салхит сайхан хар адарган нь тэнжирээд байдаг
Жил жилээр туулан өнгөрч болшгүй
Жаргалтайхан жаран шар хөндий униар татан
дүнхийгээд байдаг
Жаргалтай сайхан нутаг гэлээ лөө
15. Агар зандан хоер авалцаж ургасан
Олон сайхан модон нь нэр тоогүй гэлээ лөө
Агь хотон хоер авалцаж ургасан өнө сайхан өвсөнд нь

Тун зай завсаргүй гэлээ гэж говь нутгийн байгалийн зураглалыг шүлэглэхдээ эр хүний бяр чадалыг шавхсан, сайн хүлгийн жолоо хүрч чадашгүй, сар сараар туулан өнгөрч болшгүй далан улаан элс хязгааргүй уудамд дүнхийн харагдаж хэмээн говь нутгийг цаг хугацаатай харьцуулан зэрэгцүүлсэн ба цаг хугацаанд энэ ертөнцийн бодит ахуй хүчин мөхөсдөг гэж үзвэл говь нутгийг туулах цаг хугацаа хүршгүй хэмээн шүлэглсэн нь говь нутгийн хязгааргүй уудам орон зайг илэрхийлжээ.

Тэрхүү газар нутгийн байгалийн баян тансаг үзэмжийг тодотгохдоо агь хотон, агар зандан хоер авалцаж ургасан, өн сайхан өвсөнд нь тун зай

завсаргүй гэлээ өө хэмээн нутгийн жимс идээгээр нь магтан шүлэглсэн бол /Б/ хувилбарын: Говь нутгийн магтаал нь /А/ хувилбарын эхний бадаг шүлэгтэй ерөнхий утга агуулга адилхан боловч говь нутгийн жимс идээний магтаал буюу /15-18/ мөр шүлгийг /Б/ хувилбарт олон зүйлийн өргөн сайхан нутаг хэмээн товчлсон байдаг. Мөн /А/ хувилбарын 10-15 хүртлэх мөр шүлэг /Б/ хувилбарт огт байхгүй байдаг.

Говь нутгийн магтаал нь /А/ хувилбарт 5-15 дугаар мөр шүлэг буюу цаг үеийн магтаалын дараа орж байгаа бол /Б/ хувилбарт 135-146 дугаар мөр шүлэг буюу Алтай нутаг, өвс ургамал, булаг ус, ан амьтны магтаалын дараа орж, өгүүлэмжийг логик дараалал нь өөр өөр байна. Мотивийн дараллын дагуу /А/ хувилбарын Ан амьтны магтаалд:

Ид ихтэй араатан идэлдэн харгалдаад
Яруу дуутай өлөн шувуу нь шуугин донгодоод
Жаран бошгирууд /2в/ жийгэн жиргэлдээд
Жаран өнгийн гөрөөс нь дагалдаж идээлээд байдаг

гэж 30-34 дүгээр мөр шүлгэнд ан амьтныг үйл хөдлөлд оруулан утга агуулгаа богино богино богино өгүүлбэрээр товчхон илэрхийлсэн бол /Б/ хувилбарын «Ан амьтны магтаал»-д хэрхэн дүрсэлсэнийг үзье:

110 Ид ихтэй араатан
Идээшлэн харгиад байдаг
Гунан хар бүргэд
Гурвалжуу дундаан
Мэгнэн хагшаад байдаг
115 Гурван тивийн амьтан
Найр жаргал дундаан
Ташууран жаргаад байдаг
Дөнөн хар бүргэд
Дөрөлж дундаан мэгнэн хагшаад байдаг
120 Дөрвөн тивийн амьтан
Найр жаргал дундаан
Ташууран жаргаад байдаг
Оенго зүйлийн
Арван гурван алтан нутаг
125. Нэгэн дүнхийгэд байдаг

гэлээ гэх мэтчилэн ан амьтныг дүрслэхдээ улирал, байгальтай нь холбон амьтныхаа насны зааг ялгаа, байгаль орчин ахуй, замбу тив ертөнц, гэх үндсэн дараалаар толгой холбосон байна. Ан амьтныг орчин ахуй тусагдахуунтай /объект/ нь холбогдуулан дүрсэлсэн ба найр жаргал дундаан ташууран жаргаад байдаг гэх мөр шүлгүүдээр хашилт хийсэн байна. Энэхүү хувилбарын дүр, дүрслэл нь /А/ хувилбарыг бодвол нилээд дэлгэрэнгүй шүлэглэжээ. Мөн ан амьтны магтаалыг /А/ хувилбарт 30-34 дүгээр мөр шүлгэнд дүрслэн бол энэ хувилбарт 100-125-дугаар мөрөнд орсон байгаа нь уг Бум эрдэнэ туулийг хайлсан туулч уран сэтгэмжээр баяжуулсан байна.

Бум Эрдэнэ туулийн Гол мөрөн, нуур, далай тэнгис, рашаан булаг усны магтаал нь /А/ хувилбарт агуулгын хувьд нилээд товчхон өгүүлсэн байна. /Б/ хувилбарт маш өргөн цар хүрээтэй дүрсэлэн байх ба доор харьцуулан нийтлэг ба ялгаатай талыг шинжлэн үзье. /А/ хувилбарын «Гол мөрөн, нуур, далай тэнгисийн магтаал»

Анамал тэнгис арвин их далай мэлмэлзээд байдаг
Тунамал тэнгис түмэн тогтоол нуур
Дүүрэгтэн цайлзаад байдаг
40. Нэртэй зуун их гол
Улибаран урсаад

гэж 37-41 дугаар мөр шүлгэнд маш хураангуйгаар гол мөрөн, нуур, далай тэнгисийг гаднах өнгө төрх, харагдах байдлаар нь магтан шүлэглэсэн ба улибаран урсаад гэх мөрийн араас залгуулан «Рашаан булаг усны» магтаал үргэлжлэх нь:

нэвтэрсэн бум олон булаг нь
Бургин буцлаад, өнгө бүрийн цэцэг дэлгэрэн ганхаад
Өвчин бүрийн рашаан нь улбарч урсаад байдаг
Найман амт бүрдсэн рашаан булгийн ус тэр гэлээ
Тээлж (уулын өндөрт байх талбай бэлчээр) ихтэй
Төвшин сайхан нутгийн нь

Тойм товч тэр гэлээ гэж рашаан булаг ус найман амт бүрдсэн хэмээн тус тусын онцлогтой болохыг товчхон өгүүлсэн бол /Б/ хувилбарын Гол мөрөн, нуур, далай тэнгисийн магтаал нь /А/ хувилбарын Гол мөрөн, нуур, далай тэнгисийн магтаал /37-41/-р мөр шүлгэн дээр

Түмэн төгрөг нуур ногооход
Буян ихтэй цагаан далай цайлзаад

байдаг гэх мөрүүд нь нэмэгдсэн уран дүрслэл илүү дэлгэрэнгүй байгаа нь харагдаж байна. /Б/ хувилбарын «Рашаан булаг усны магтаал»-ыг авч үзвэл:

Бум олон булаг ус нь
Булгин буцлаад байдаг
Оенго бүрийн цэцэг
Дэлгэрэн ганхаад байдаг гэлээ
80 Өвчин бүгдийн эм болсон
Рашаан булаг ус нь
Шингэн олон булгийн усан
Ширгээн дагаад
Шимээлтэн урсаад байдаг
85 Шингэхэн дуутай хөхөө
Шилээн даган
Шилэвхэн донгодоод байдаг
Оенго зүйлийн
Өргөн сайхан алтан нутаг гэлээ
90 Даль Суль хоер
Дарцан ганхаад байдаг
Давхар олон цэцэг түшэлдэн ганхаад байдаг
Дав бүгдээс
Далан эхтэй
95 Хүйтэн хар ус нь
Оргилон урсаад байдаг
Давхар бүгдээс далан эхтэй рашаан
Даржигнатал урсаад байдаг

хэмээн шүлэглсэн нь /А/ хувилбарын рашаан булаг усны магтаалаас илүү дэлгэрэнгүй дүр дүрслэл ихтэй байна. Хар ус оргилон урсаад, давхар олон

цэцэг түшилдэн ганхаад, даль суль хоер дарцан ганхаад, байдаг гэгчлэн рашаан булаг усыг ан амьтантай нь холбогдуулан үйл хөдлөлд оруулсан байгалийн зураглалыг илүү тодорхой шүлэглэжээ.

Дүгнэлт. /А/ хувилбарын рашаан булаг усны магтаал нь 41-45-р мөр шүлэгт, ан амьтан, гол мөрөн, нуур, далай тэнгисийн магтаалын дараа адуун сүргийн магтаалын өмнө нь орсон бол /Б/ хувилбарт ан амьтны магтаалын өмнө дүрсэлснийг өгүүлэмжийн дараалын утга агуулгаас нь харьцуулан үзвэл /Б/ хувилбар нь илүү оновчтой дараалалд оруулсан нь харагдаж байна. Гэх мэтчилэн дээрх хоер хувилбарын оршил хэсгийн магтаалаас тодорхой хэдэн өгүүлэмжийг сонгон авч ерөнхийлөн харьцуулан өгүүлвэл утга агуулгаараа таарч байгаа зүйл нилээд байгаа боловч дүр дүрслэгдэхүүний доорх хэдэн ялгаа харагдаж байна.

1. /А/, /Б/ хувилбарын өгүүлэмжийн байрлал өөр өөр;
2. /А/ хувилбарын дүрслэл товчхон;
3. /Б/ хувилбарт өөр өөр шинэ дүрслэл нэмэгдсэн;
4. /А/ хувилбарт хэмжээ тоог цаг хугацаатай зүйрлэсэн;
5. /Б/ хувилбарт утга салгасан мөр шүлгүүд их

гэх зэрэг ялгаануудаас харахад /А/ хувилбарыг бодвол /Б/ хувилбар нь илүү их уран дүрслэл ихтэй болох нь харагдаж байна. Энэхүү ялгаатай байдал нь бичгийн хувилбараас аман хувилбар, аман хувилбараас бичгийн хувилбарт шилжихэд өөрчлөгдсөн байх магадлалтай юм.

Амаар буюу бичгээр боловсорсон туулиудын хооронд өгүүлбэр зүйн, нутгийн аялгуунаас төв халх аялгуунд буулгахад нь өвөрмөц ялгаа, зарим алдаа дутагдал гарч болох олон олон шалтгаануудаас үүдэлтэй юм.Энэ мэтчилэн уг туулийн утга агуулгыг олон өгүлэмжинд ангилан харьцуулан үзвээс нилээд ялгаа харагдаж байна. Үүнээс цааш дэлгэрүүлэн үлдсэн өгүүлэмжийг харьцуулан үзэхэд /А/ хувилбарын оршил хэсгийн магтаалын сүүлчийн өгүүлэмж (мотив) болох «Сүм дуганы магтаал» нь /Б/ хувилбарт огт байхгүй ба шашны үг хэллэг нилээд зууралдангуй эртний хэлбэрээр шүлэглэсэн байдаг.

Ном зүй

1. Аман зохиол судлал. Улан-Батор, 1997. XX боть.
2. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Улан-Батор, 1966.
3. Сүхбаатар О. Монгол хэлний харь үгийн толь. Улан-Батор, 1992.
4. Сүхбаатар О. Монгол хэлний харь үгийн толь. Улан-Батор, 1997.
5. Цолоо Ж., Пүрэвжав Э. Бурхан хааны хөвүүн балчир Бум Эрдэнэ-ийн есөн бөлөг. Улан-Батор, 1997.
6. Лувсанбалдан Х. Бурхан хаан аавтай бурам хатан ээжтэй эрийн сайн Бум Эрдэнэ-ийн есөн бөлөг. Улан-Батор, 1997.
7. Balsan T. Study on skills and life of M.Parchiny, the famous narrator. Улан-Батор, 2006.
8. Gaadamba Sh. Mongolian folk heroic epic. Улан-Батор, 1982.
9. Katuu B. Bayad folk epics. Улан-Батор, 2003.
10. Katuu B. Comparative study of «Bum-Erdene» epic. Улан-Батор, 2014.

BIOGRAPHY OF M. PARCHIN AND HIS ARTISTIC SKILL

Oyun
Inner Mongolia Normal University
81, Zhaowuda Rd, Huh-Hoto, 010020 China

The Bayad M. Parshin is the best and well-known narrator from Khyargas soum, who distinguished himself by his epic poems during end of XIX century and beginning of XX century. He had been narrating several decades of epic poems such as «Ergil Turgel», «Bum-Erdene», «Dani Khurel» etc. and as he met with A.V. Burdukov who was a merchant of Soviet Union, then latter he became a famous Mongolist, had been brought to introduce Mongolian epic poems throughout Europe, and hereditary Russian Mongolian experts. L. Kotvich and B.Ya. Vladimirtsov were uniquely an oral wisdom carriers of intangible cultural heritage. However so many people studied autobiography of the narrator, there are few works, devoted to characteristics of his artistic skill. The author considers autobiography and narration skill of M. Parchin.

Keywords: folklore; epos; preface; praise; artistic skill; biography; composition; version; performance; image.